



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГ АГЕНТЛАГ
ХОТЫН СТАНДАРТ ХЯНАЛТЫН ГАЗАР

СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
2022-2025 ОН



2022 ОН

Хотын стандарт, хяналтын газрын стратеги төлөвлөгөө 2022-2025


Төлөвлөгөөг баталсан:
Хотын стандарт, хяналтын газрын дарга.
 (албан тушаал)

Төлөвлөгөөг боловсруулсан:
Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
Ажлын хэсгийн дарга
 (албан тушаал)



(гарын үсэг)

Тэмдэг



(гарын үсэг)

Тэмдэг

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
 даргын 2020 оны 100 дугаар тушаалын
 2 дугаар хавсралт

Төсвийн шууд захирагч
/С.Төмөрдулам/

(огноо)

2022-02-25

/Э.Даваахатан/
 (огноо)

**ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН 2022-2025 ОНД
 ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**
 /Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг/

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр
<i>Ерөнхий чиг үүргийн нэр: 6.1 Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задалж, орон сууц дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологи нэвтрүүлнэ.</i>					
<i>Үндсэн чиг үүргийн нэр: 4.1.2. хотын стандартыг боловсруулах, эрх бүхий байгууллагаар батлуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих;</i>					
Зорилт-1. 6.1.5. Хотын стандарт, норм дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	арга хэмжээ-1 хотын стандартын төслийн суурь судалгааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	Судалгааны ажлын тоо	22	41	Нийслэлийн Төсвийн хөрөнгө оруулалтаар
	арга хэмжээ-2 Хотын стандартын төслийг боловсруулж, НИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах	Батлагдсан хотын стандарт	-	97	Нийслэлийн Төсвийн хөрөнгө оруулалтаар
	арга хэмжээ-3	Үйл ажиллагааны	30%	100%	Нийслэлийн Төсвийн хөрөнгө оруулалтаар

Хотын стандарт, хяналтын газрын стратеги төлөвлөгөө 2022-2025

	Шинэчлэн сайжруулах шаардлагатай стандарт, нормын судалгаа хийж холбогдох байгууллагуудад үндэслэл бүхий санал боловсруулж хүргүүлэх	хэрэгжилт, хувь			
Үндсэн чиг үүргийн нэр: 4.1.1 нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх;					
Зорилт-2 Хотын стандартын тогтолцооны эрх зүйн орчныг бүрдүүлэх	арга хэмжээ-1 Хотын стандартын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, судалгаа хийх, хотын стандартын төслийг боловсруулах, батлуулах үйл ажиллагааны журмын төсөл боловсруулж батлуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	30%	100%	Нийслэлийн Төсвийн хөрөнгө оруулалтаар
	арга хэмжээ-2 Хотын стандартын төслийг хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, үндэсний стандарт болон норм дүрэмд нийцүүлэх хянан хэлэлцэх “Хотын стандартын зөвлөлийн дүрэм”-ийн төсөл боловсруулж батлуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	30%	100%	Нийслэлийн Төсвийн хөрөнгө оруулалтаар
	арга хэмжээ-3 Хотын стандартын тогтолцоог хөгжүүлэхтэй холбоотой асуудлаар хууль эрх зүйн орчны судалгаа хийх, өөрчлөлт оруулах шаардлагатай хууль, тогтоомжийн төсөлд өгөх саналыг боловсруулж дээд шатны байгууллагад уламжлах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Нийслэлийн Төсвийн хөрөнгө оруулалтаар
Үндсэн чиг үүргийн нэр: 4.1.6. Стандарт, норм, дүрмийг мөрдүүлэхэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг мэдээлэл, сургалт, арга зүйгээр хангах, зөвлөн туслах, сурталчлан таниулах					
Зорилт-3 Стандартын талаарх бүх нийтийн мэдлэг, ойлголтыг төлөвшүүлэх	Арга хэмжээ-1 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдад стандарт, нормын талаарх мэдлэг, ойлголтыг төлөвшүүлэх арга хэмжээг жил бүр төлөвлөн зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Нийслэлийн Төсвийн хөрөнгө оруулалтаар
	Арга хэмжээ-2 Иргэд олон нийтэд стандартын талаар сурталчилан таниулах олон талын арга хэмжээг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Нийслэлийн Төсвийн хөрөнгө оруулалтаар
<i>Ерөнхий чиг үүргийн нэр: Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл: 5.3.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад олон улсын Чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлсэн байна.</i>					
Зорилт-4 Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангуулж Чанарын	Арга хэмжээ-1 Газрын дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд хангалттай хүний нөөцийг бүрдүүлж Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Нийслэлийн Төсвийн хөрөнгө оруулалтаар

Хотын стандарт, хяналтын газрын стратеги төлөвлөгөө 2022-2025

удирдлагын тогтолцооны стандартыг нэвтрүүлэх	Арга хэмжээ-2 Газрын үйл ажиллагаанд Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001 стандартыг нэвтрүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Нийслэлийн Төсвийн хөрөнгө оруулалтаар
	Арга хэмжээ-3 Чанарын удирдлагын тогтолцоог нийслэлд нэвтрүүлэх хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудыг зөвлөмж арга зүйн дэмжлэг үзүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Нийслэлийн Төсвийн хөрөнгө оруулалтаар
<i>Ерөнхий чиг үүргийн нэр: 9.5.3 Хотын стандартын дагуу орчны аюулгүй байдлын хяналт, шалгалтыг сайжруулж, иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулсан байна.</i>					
<i>Үндсэн чиг үүргийн нэр: 4.1.7.Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах.</i>					
Зорилт-5 Стандарт, нормын хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулна.	Арга хэмжээ-1 Бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд стандарт, нормыг мөрдүүлэхэд захиалагч, гүйцэтгэгч байгууллагуудад зөвлөн туслах, арга зүйгээр хангах арга хэмжээг жил бүр төлөвлөгөөний дагуу зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Нийслэлийн Төсвийн хөрөнгө оруулалтаар
	Арга хэмжээ-2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангуулах, цахим системд шижлүүлэх ажлын үе шаттай хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Нийслэлийн Төсвийн хөрөнгө оруулалтаар
	Арга хэмжээ-3 Иргэдийн эрүүл аюулгүй байдалд эрсдэл учруулж, шаардлагад нийцээгүй зөрчлийг арилгуулж, стандарт, норм дүрмийн хэрэгжилтийг хангуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Нийслэлийн Төсвийн хөрөнгө оруулалтаар

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ БАТЛУУЛАХ

АЖЛЫН ХЭСЭГ

**ХОТЫН СТАНДАРТ ХЯНАЛТЫН ГАЗРЫН 2022-2025 ОНЫ
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

1. Нийтлэг үндэслэл
2. Мандатын шинжилгээ
3. Алсын хараа
4. Эрхэм зорилго
5. Орчны шинжилгээ
6. Стратегийн зорилго
7. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги
8. Стратегийн зорилго ба салбар, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын бүтцийн уялдаа, зураглал
9. Хавсралт

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 100 дугаар тогтоолоор “Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар” нэртэй Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийг үүсгэн байгуулахаар шийдвэрлэсэн. Тус газрыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын бүтцэд бий болгох хууль, эрх зүйн үндэслэл, шаардлага нь хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд тусгасан дараах хэд хэдэн заалтуудтай хамааралтай юм. Үүнд:

- Монгол улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д Монгол улсын иргэн нь “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасны дагуу Нийслэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх, бүтээн байгуулах, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангуулах цогц арга хэмжээнд дэлхийн жишигт нийцсэн хотын стандартыг мөрдүүлэх зайлшгүй шаардлага тулгарсан.

- Улсын Их хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын баримт бичгийн 3 дугаар бүлэг “Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам”-д

....3.4 Хүний аюулгүй байдал

....3.5 Хүрээлэн буй орчны аюулгүй байдал гэсэн бүлэг асуудлыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд нийслэл Улаанбаатар хотын иргэдийн эрүүл, аюулгүй амьдралын орчинг бүрдүүлэх арга хэмжээний шалгуур үзүүлэлт болсон стандарт, нормыг бий болгож мөрдүүлэх нь салшгүй үйл хэрэг болно.

Улаанбаатар хотын иргэдийн амьдрах орчны эрүүл, аюулгүй, ая тухтай байдал алдагдаж Монгол улсын үндсэн хуулиар олгосон эрх зөрчигдөх түвшинд хүрсэн нь хот байгуулалт, тохижилт, нийтийн аж ахуйд мөрдөх стандарт, нормын хэрэгжилт хангалтгүй байгаатай холбоотой гэж Нийслэлийн удирдлагын зүгээс үзэж Улаанбаатар хотод мөрдөх стандарт, нормыг шинэчлэн сайжруулах, хэрэгжүүлэх тогтолцоог хөгжүүлэхын тулд дараах томоохон арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Нийслэл хот өөрийн гэсэн стандарттай болох үүднээс “хотын стандарт”-ын асуудлыг хариуцан зохион байгуулах нийслэлийн нутгийн захиргааны нэгж, байгууллагыг бий болгож хөгжүүлэх зорилгоор нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийг байгуулсан.

- Хотын стандартыг хөгжүүлэх эрх зүйн орчны бүрдүүлэх хүрээнд Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт “Улаанбаатар хот ба дагуул хот” гэж тодорхойлсон ба түүний 9.4-д “Хууль, эрх зүйн тогтвортой орчинтой, хотын дүрэм, стандартыг хангуулсан сайн засаглалтай хот болно” гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

- Нийслэлийн Засаг даргын санаачилгаар 2019 онд “Нэг хот-Нэг стандарт” анхдугаар зөвлөгөөнийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын дунд зохион байгуулж хотын стандартыг бий болгох, стандартын хэрэгжилтийг сайжруулах талаар нэгдсэн бодлого, зарчмыг дэвшүүлж улмаар 2020 оныг “Нэг хот-Нэг стандарт” зорилтот жил болгож болзолт уралдааныг зарлан зохион байгуулсан. Энэ үед дэлхий дахинаа Коронавирүст цар тахал дэгдэж “Нэг хот-Нэг

стандарт” зорилтот жилийн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэхэд багагүй бэрхшээлт тулгарч байсан боловч стандарт, норм дүрмийн суурь судалгааг 22 бүлэг сэдвийн хүрээнд гүйцэтгэж “Хотын стандарт”-ийг бий болгон үндсэн нөхцөлийг бүрдүүлж чадсан.

- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дунд хотын стандартын талаар ойлголтыг бэхжүүлж үйл ажиллагаандаа мөрдүүлэх талаар Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/456, 2021 оны А/276 дугаар захирамжуудыг тус тус батлуулан мөрдүүлсэн.

- Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиуд шинэчлэн батлагдаж “хотын стандарт”-ын хууль эрх зүйн үндэс суурийг бий болгосон.

Дээрх хууль, тогтоомжууд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 360 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/1059 дүгээр захирамжаар нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталж “Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар”-ыг “Хотын стандарт, хяналтын газар” болгон шинэчилж 6 нэгж, 60 хүртэлх орон тоотой байхаар тогтоосон. Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” А/112 дугаар захирамжаар тус газрын үндсэн чиг үүргийг шинэчлэн тодорхойлсон.

Иймд дээрх хууль, тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын дагуу Хотын стандарт, хяналтын газрын 2022-2025 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсрууллаа.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/1059 дүгээр захирамжаар Хотын стандарт, хяналтын газрын бүтэц, орон тоог, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/112 дугаар захирамжаар тус газрын дүрэм, үндсэн чиг үүргийг тус тус шинэчлэн баталсан. 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, илүү цогц, оновчтой тодорхойлогдсон.

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг тус тус мөрдлөг болгон дараах 3 алхмаар байгууллагын мандатын шинжилгээг гүйцэтгэлээ.

1. Хууль тогтоомжоос байгууллагын үйл ажиллагаанд хамаарах чиг үүргийг тодорхойлж тухайн чиг үүргүүдийг үйл ажиллагааны чиглэлээр ангилах;
2. Чиг үүргийг хэрэгжүүлэхэд холбогдогч талуудын оролцоог тодорхойлох;
3. Чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг тодорхойлох.

2.1 Хууль, тогтоомжуудаас тус газрын үндсэн үйл ажиллагаанд хамаарах хууль, тогтоомжууд, холбогдох зүйл, заалтыг тодорхойлов (Алхам-1). Үүнд:

Мандатын шинжилгээний хүснэгт

№	Хууль тогтоомжийн нэр	Холбогдох зүйл, заалт
Монгол улсын хууль		
1	Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	24.1 Нийслэлийн чиг үүрэг: 24.1.15.хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалт
2	Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль	8.3.Нийслэл хот нь дараах бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ: 8.3.3.орчны аюулгүй байдал; 21.1 Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрх 21.1.3.нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэх талаар хуульд нийцүүлэн дүрэм, журам, стандарт, заавар батлах
3	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай	10 ¹ дугаар зүйл. Хотын стандарт 10 ¹ .1.Хотын удирдлагаас иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах чиг үүргийнхээ хүрээнд стандарт батлан хэрэгжүүлж болно. 10 ¹ .2.Хотын стандарт нь үндэсний стандарт, техникийн зохицуулалтын үзүүлэлт, шаардлагад нийцсэн байна.
4	Хот байгуулалтын тухай хууль	9.1.5.хот байгуулалтын үйл ажиллагаа болон газар ашиглалт, хамгаалалтад хяналт тавих
5	Барилгын тухай хууль	35.1.6 Барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах;
Засгийн газрын тогтоол		
1	Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм
Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол		
1	- Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	5.3.1 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2016, MNS ISO 18091 стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх талаар зөвлөмж, арга зүйгээр хангах, хамтран ажиллах
2	- Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	5.6.3 Нийслэлийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, аюулгүй байдлыг хангах стандартыг мөрдүүлнэ. Үүнд: - Ундны усны эх үүсвэрийг хамгаалах, үерийн усны барилга байгууламж, ус хуримтлуулах, хөв цөөрөм үүсгэх, ус дахин ашиглах хотын стандарт, норм, дүрмийг боловсруулж, мөрдүүлнэ.

		<p>- Ногоон байгууламжийн техникийн ерөнхий шаардлага, төлөвлөлт хийх удирдамж, арга зүйн баримт бичиг боловсруулж мөрдүүлнэ</p> <p>- Хот доторх оршуулгын үйл ажиллагаа явуулдаг газрын орчны цэцэрлэгжүүлэлтийн орчны аюулгүй байдлыг хангах, хотын стандарт, норм, дүрмийг боловсруулж, мөрдүүлнэ.</p> <p>6.1.5 Хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.</p>
3	<p>- НИТХ-ын Тэргүүлэгчийн 2018 оны "Иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" 119 дүгээр тогтоол</p>	<p>1.3.1 Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага бүр өмчийн харьяалал үл хамааран орчны тохижилт, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, стандартын шаардлагыг баримтлан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, насанд хүрээгүй хүүхэд зэрэг онцгой анхаарал халамж шаардах иргэдийн эрх ашгийг нэн тэргүүнд хангасан байх</p>

Хотын стандарт, хяналтын газрын үйл ажиллагаатай холбоотой 5 хууль, 3 тогтоол болон газрын шинэчлэн баталсан дүрмийг судалж үзвэл ерөнхий чиг үүрэг-2, үндсэн чиг үүрэг-6, дэд чиг үүрэг-22 байна гэж тодорхойллоо. /хүснэгт №01/

Хотын стандарт, хяналтын газрын чиг үүрэг

Хүснэгт №01: Хотын стандарт, хяналтын газрын чиг үүрэг

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо	5	
Үүнээс: Тухайн салбарын хуулийн тоо	3	
Нийтлэг мөрддөг хуулийн тоо	2	
Ерөнхий чиг үүрэг-1: Хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
Үндсэн чиг үүрэг-1: Хотын стандартыг боловсруулах	Хот байгуулалт, хот нийтийн аж ахуй, байгаль орчин, худалдаа, үйлчилгээний салбарт хэрэгжиж буй хууль, тогтоомж, бодлогын баримт бичиг, норм, стандарт, олон улсын туршлага, Улаанбаатар хотын тухайн цаг үеийн нөхцөл байдал зэргийг судлан дүн шинжилгээ хийх, нийслэлд баталж мөрдүүлвэл зохих хотын стандартын эрэлт хэрэгцээг тодорхойлох;	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд
	Хотын стандарт боловсруулах ажлын даалгаврын төсөл боловсруулах	

	Хотын стандартын төслийг ажлын даалгаварт нийцүүлэн боловсруулах	
	Хотын стандарт боловсруулах хүрээнд холбогдох төрийн байгууллага болон мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах	СХЗГ
	хотын стандарт батлуулах талаар бусад байгууллага, аж ахуйн нэгжид мэргэжлийн туслалцаа үзүүлэх, арга зүйгээр хангах	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд
Үндсэн чиг үүрэг-2 Хотын стандартыг батлуулах	Хотын стандартын төслийг хянан тохиолдуулж холбогдох хууль тогтоомж, үндэсний стандарт, норм, дүрэмтэй харьцуулан нийцлийг тодорхойлох,	НЗДТГ, СХЗГ
	хотын стандартын төслийн нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг судлах, нөлөөллийн шинжилгээ хийх	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд
	Хотын стандартын сонирхогч талууд, оролцогчдын хүрээг тодорхойлж тэдгээрээс саналыг нэгтгэн боловсруулж дүгнэлт гаргах,	
	Хотын стандартыг Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах ажлыг зохион байгуулах	НЗДТГ
Үндсэн чиг үүрэг-3 Хотын стандартын баримт бичгийн лавлагаа, мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх;	НИТХ-аас баталсан хотын стандартыг бүлэг, ангилал, нэр, дугаарыг бүртгэх	СХЗГ
	Хотын стандартын цаасан болон цахим санг бүрдүүлэх, хөтлөх, баяжуулах	НЗДТГ, НМТГ
	Хотын стандартын талаарх лавлагаа, мэдээллээр шаардлагатай байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг хангах	НХМОХГ
Ерөнхий чиг үүрэг-2: Стандарт, нормын хэрэгжилтийг зохион байгуулах		
Үндсэн чиг үүрэг-4 Хотын стандартын удирдамж, арга зүйн тогтолцоог хөгжүүлэх	Хотын стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтийг үнэлэх, аргачлал, заавар, шалгуур үзүүлэлтийг боловсруулах	НЗДТГ
	Хот байгуулалт, хот нийтийн аж ахуй, байгаль орчин, худалдаа, үйлчилгээний салбарт стандарт, норм, дүрмийг мөрдүүлэхэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд зориулсан сургалт зохион байгуулах, арга зүйгээр хангах	НССОНХГ

	Хотын стандартыг иргэд олон нийтэд сурталчилан таниулах	НССОНХГ
Үндсэн чиг үүрэг-5 Стандарт, нормын хэрэгжилтийн байдалд хяналт тавих, зөвлөн туслах	Хотын стандартыг нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх талаар нэгдсэн арга хэмжээг төлөвлөж тухайн жилийн нийслэлийн хөгжлийн төлөвлөгөө, холбогдох байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	НЗДТГ, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд
	Хот байгуулалт, хот тохижилт, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд стандарт, нормыг мөрдүүлэх талаар захиалагч, гүйцэтгэгч байгууллагуудыг зөвлөмж, арга зүйгээр хангах	НССОНХГ
	Стандарт, нормын зөрчил болон иргэдийн амьдрах орчинд үүссэн эрсдэлийг бууруулахад холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах	НМХГ, НГЗБА, ХБХГ, НЦУГ
Үндсэн чиг үүрэг-6 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах	Барилга байгууламж, их засвар, тохижилтын ажлыг ашиглалтад оруулах комиссын хуваарь боловсруулж эрх бүхий албан тушаалтнаар батлуулах	НЗДТГ
	Ашиглалтад орж буй барилга байгууламжийн гүйцэтгэл, стандартын хэрэгжилтийг хянах	НМХГ, ХБХГ, НХОГ
	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хурлыг зохион байгуулах, хурлын тэмдэглэл, дүгнэлтийг баталгаажуулах	НМХГ, НХОГ
	Ашиглалтад орж буй барилга байгууламжийн талаарх атрибут мэдээллийг бүртгэх, холбогдох мэдээллийн санг баяжуулах	БХБЯ, НХОГ

2.2 Газрын үндсэн болон дэд чиг үүргийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын оролцоог дараах байдлаар тодорхойлов. (Алхам-2)

2.2.1 Хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх ерөнхий чиг үүргийг хэрэгжүүлэхэд холбогдох бусад байгууллагууд дараах байдлаар оролцоно.

Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Оролцогч байгууллага, оролцооны хэлбэр
Хотын стандартыг боловсруулах	Хот байгуулалт, хот нийтийн аж ахуй, байгаль орчин, худалдаа, үйлчилгээний салбарт хэрэгжиж буй хууль, тогтоомж, бодлогын баримт	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд: Дүрмээр хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагааныхаа чиглэлээр хотын стандартыг бий болгох талаар

	бичиг, норм, стандарт, олон улсын туршлага, Улаанбаатар хотын тухайн цаг үеийн нөхцөл байдал зэргийг судлан дүн шинжилгээ хийх, нийслэлд баталж мөрдүүлвэл зохих хотын стандартын эрэлт хэрэгцээг тодорхойлох;	санал дэвшүүлэх, холбогдох судалгааны тоон мэдээллээр хангах
	Хотын стандарт боловсруулах ажлын даалгаврын төсөл боловсруулах	Ажлын даалгаварт санал өгөх
	Хотын стандартын төслийг ажлын даалгаварт нийцүүлэн боловсруулах	Хотын стандартын төсөлд санал өгөх
	Хотын стандарт боловсруулах хүрээнд холбогдох төрийн байгууллага болон мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах	Стандарт хэмжил зүйн газар: Хотын стандарт нь үндэсний стандартад нийцсэн эсэх талаар дүгнэлт, санал өгөх
	хотын стандарт батлуулах талаар бусад байгууллага, аж ахуйн нэгжид мэргэжлийн туслалцаа үзүүлэх, арга зүйгээр хангах	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд: Хотын стандартын төсөл боловсруулахдаа мэргэжлийн туслалцаа авах
Хотын стандартыг батлуулах	Хотын стандартын төслийг хянан тохиолдуулж холбогдох хууль тогтоомж, үндэсний стандарт, норм, дүрэмтэй харьцуулан нийцлийг тодорхойлох,	НЗДТГ: Нийслэлийн хөгжлийн бодлогын зорилт, арга хэмжээ, холбогдох хууль тогтоомжтой уялдсан эсэхийг дүгнэж санал өгөх СХЗГ: Хотын стандарт нь үндэсний стандартад нийцсэн эсэх талаар дүгнэлт, санал өгөх
	хотын стандартын төслийн нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг судлах, нөлөөллийн шинжилгээ хийх	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд Судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх, тоон мэдээллээр хангах
	Хотын стандартын сонирхогч талууд, оролцогчдын хүрээг тодорхойлж тэдгээрээс саналыг нэгтгэн боловсруулж дүгнэлт гаргах,	Батлуулах хотын стандартыг мөрдүүлэх арга хэмжээнд хэрхэн оролцох боломжтой талаар мэдээлэл өгөх
	Хотын стандартыг Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах ажлыг зохион байгуулах	НЗДТГ: Захиргааны дэмжлэг үзүүлэх, НЗД-ын Зөвлөлийн хуралд хэлэлцүүлэх
Хотын стандартын баримт бичгийн лавлагаа, мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх;	НИТХ-аас баталсан хотын стандартыг бүлэг, ангилал, нэр, дугаарыг бүртгэх	-
	Хотын стандартын цаасан болон цахим санг бүрдүүлэх, хөтлөх, баяжуулах	Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар: Цахим системд нийтлэхэд техникийн туслалцаа үзүүлэх
	Хотын стандартын талаарх лавлагаа, мэдээллээр шаардлагатай байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг хангах	

2.2.2 Стандарт, нормын хэрэгжилтийг зохион байгуулах ерөнхий чиг үүргийг хэрэгжүүлэхэд холбогдох бусад байгууллагууд дараах байдлаар оролцоно.

Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Оролцогч байгууллага, оролцооны хэлбэр
Хотын стандартын удирдамж, арга зүйн тогтолцоог хөгжүүлэх	Хотын стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтийг үнэлэх, аргачлал, заавар, шалгуур үзүүлэлтийг боловсруулах	НЗДТГ: Захиргааны дэмжлэг үзүүлж удирдлагаар хангах
	Хот байгуулалт, хот нийтийн аж ахуй, байгаль орчин, худалдаа, үйлчилгээний салбарт стандарт, норм, дүрмийг мөрдүүлэхэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд зориулсан сургалт зохион байгуулах, арга зүйгээр хангах	НССОНХГ: Сургалт зохион байгуулах хүрээнд хамтран ажиллах
	Хотын стандартыг иргэд олон нийтэд сурталчилан таниулах	НССОНХГ: Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай харилцах, хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх
Стандарт, нормын хэрэгжилтийн байдалд хяналт тавих, зөвлөн туслах	Хотын стандартыг нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх талаар нэгдсэн арга хэмжээг төлөвлөж тухайн жилийн нийслэлийн хөгжлийн төлөвлөгөө, холбогдох байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	НЗДТГ, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд: Чиг үүргийнхээ хүрээнд хотын стандарт мөрдөх талаар хамтран ажиллах
	Хот байгуулалт, хот тохижилт, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд стандарт, нормыг мөрдүүлэх талаар захиалагч, гүйцэтгэгч байгууллагуудыг зөвлөмж, арга зүйгээр хангах	НССОНХГ: Сургалтын хөтөлбөр, анги танхимаар хангах ХБХГ, НХОГ: Холбогдох ААНБ-ыг сургалтанд хамруулах талаар дэмжлэг үзүүлэх
	Стандарт, нормын зөрчил болон иргэдийн амьдрах орчинд үүссэн эрсдэлийг бууруулахад холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах	НМХГ, НГЗБА, ХБХГ, НЦУГ Чиг үүргийнхээ хүрээнд зөрчлийг арилгах ажилд оролцох
Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн	Барилга байгууламж, их засвар, тохижилтын ажлыг ашиглалтад оруулах комиссын хуваарь боловсруулж эрх бүхий албан тушаалтнаар батлуулах	Комиссын бүрэлдэхүүн байгууллагууд: Чиг үүргийнхээ хүрээнд комиссын үйл ажиллагаанд оролцох
	Ашиглалтад орж буй барилга байгууламжийн гүйцэтгэл, стандартын хэрэгжилтийг хянах	
	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хурлыг зохион	

зохион байгуулах	байгуулах, хурлын тэмдэглэл, дүгнэлтийг баталгаажуулах	
	Ашиглалтад орж буй барилга байгууламжийн талаарх атрибут мэдээллийг бүртгэх, холбогдох мэдээллийн санг баяжуулах	БХБЯ, НХОГ Мэдээллийн санг хүлээн авч нэгтгэх

2.3 Чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг дараах байдлаар тодорхойлов (Алхам-3)

Тус газар нь 2019 онд байгуулагдсан цагаасаа хойш дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллажээ.

№	Дүрмээр хүлээсэн үүрэг 2021	Үүргийн биелэлт
1	Иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчинг бүрдүүлэх зорилгоор хот төлөвлөлт, хот байгуулалт, хот нийтийн аж ахуй, хүрээлэн буй орчны аюулгүй байдал, зохион байгуулалт, менежментийн чиглэлээр судалгаа хийх.	<p>Иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчинг бүрдүүлэх зорилгоор хот төлөвлөлт, хот байгуулалт, хот нийтийн аж ахуй, хүрээлэн буй орчны аюулгүй байдал, зохион байгуулалт, менежментийн чиглэлээр судалгаа хийв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчин - Хүүхдийн тоглоомын талбай - Хүүхдийн Цэцэрлэгийн гадна орчин - Барилгын гадна орчны аюулгүй байдал - Тээврийн хэрэгсэл, явган хүний зорчих хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх байршлууд - Гадна авто зогсоолын стандартын шаардлагад нийцсэн эсэхэд нэгдсэн судалгааг хийх - Хороо, өрхийн эмнэлгийн цогцолбор барилгуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдал - СӨХ-ийн гадна орчин /орчны тохижилт, ногоон байгууламж, авто зогсоол/ - Нийтийн тээврийн зогсоолын стандартын хэрэгжилт - Төвийн шугам сүлжээнд холбогдоогүй худалдаа үйлчилгээний байгууллагуудад нийтийн бие засах газрын стандартад нийцүүлэх, мөрдүүлэх - Барилга угсралтын ажил зогссон сургууль, цэцэрлэгийн байршлуудын судалгаа - Орчны бохирдол үүсгэсэн, удаан хугацаанд ухсан нүхтэй, овоолсон шороотой, эвдэрч нурсан хашаатай газрын байршлууд - Нийтийн эзэмшлийн талбайгаар тохижуулах боломжтой байршлын судалгаа
	Хүрсэн үр дүн: <i>Иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор хот төлөвлөлт, хот байгуулалт, хот нийтийн аж ахуйн чиглэлээр 22 бүлгийн хотын стандартын төслийг боловсруулах стандартчиллын баримт бичиг, суурь судалгаа, тоон мэдээлэлтэй болсон.</i>	
2	Хотын стандарт, удирдамж арга зүйн баримт бичгийг боловсруулах	Хот төлөвлөлт, хот байгуулалт, барилга дэд бүтэц, хот нийтийн аж ахуйн салбарт хамаарах иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлд шууд нөлөөлж байгаа асуудлуудыг шийдвэрлэх чиглэлээр 22 бүлгийн 97 төрлийн хотын стандартын

		<p>баримт бичгийг боловсруулах ажлыг 2020-2021 онд гүйцэтгэж холбогдох сэдэв агуулгын хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны болон харьяа 53 байгууллагаас санал авч тусган сайжруулан шинээр боловсруулсан. 22 бүлгийн 97 төрлийн хотын стандартын баримт бичгийг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулсан. Хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгүүдийг нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх талаар Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Стандарт мөрдүүлэх арга хэмжээний тухай” А/276 дугаар захирамжийг батлуулан хэрэгжилтийг нийслэлийн хэмжээнд хангуулан хяналт тавьж ажиллав.</p> <p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд 2021-2024 онд боловсруулах хотын стандартын дараах баримт бичгүүдийн суурь судалгаа болон холбогдох материалыг бүрдүүлэн ажиллав. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Ундны усны эх үүсвэрийг хамгаалах, Үерийн усны барилга байгууламж, ус хуримтлуулах, хөв цөөрөм /биосвайл/ үүсгэх, ус дахин ашиглах тухай удирдамж, гарын авлага боловсруулах; 2. Ногоон байгууламжийн техникийн ерөнхий шаардлага, төлөвлөлт хийх удирдамж, 1 арга зүйн баримт бичиг боловсруулах; 3. Хот доторх оршуулгын үйл ажиллагаа явуулдаг газрын орчны цэцэрлэгжүүлэлтийн орчны аюулгүй байдлын судалгаа хийх; 4. Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын хөрсөнд дахин сэргээлт хийх ерөнхий шаардлагын судалгааг хийх 5. Ногоон барилгын стандартыг боловсруулж, батлуулахад чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах.
	<p>Хүрсэн үр дүн: <i>Хот байгуулалт, нийтийн аж ахуй, байгаль орчныг хамгаалах чиглэлд хийгдэж буй бүтээн байгуулалт, ажил, үйлчилгээний чанарыг сайжруулах, стандарт, нормыг мөрдүүлэхэд ашиглах “Хотын стандартын удирдамж, арга зүйн баримт бичиг”-ийг хэрэглээнд нэвтрүүлсэн. Энэ хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/456, 2021 оны А/276 дугаар захирамжууд батлагдан хэрэгжиж эхэлсэн.</i></p>	
<p>3</p>	<p>Стандартын хэрэгжилтийг хангуулах, мөрдүүлэх;</p>	<p>Хот нийтийн аж ахуйн нэгжийн салбарын үйлчилгээнд стандартын хэрэгжилтийг хангуулах, мөрдүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлэв. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. НЗД-ын А/456 тоот захирамжийн дагуу Газрын даргын А/25-дугаар тушаалын хүрээнд улс нийслэл, орон нутгийн төсвөөр хийгдэж буй тохижилт, бүтээн байгуулалтын ажлуудад стандарт норм дүрмийн хэрэгжилтийг хангуулан, газар дээр нь хянаж зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулан Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд нийт 121 байршилд ажиллаж стандартын хэрэгжилтийг хангуулах, мөрдүүлэн ажиллав. 2. Нийслэлийн Засаг даргын А/456, А/276 дугаар Хотын стандартын баримт бичгийг мөрдүүлэх тухай захирамжийн хүрээнд улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх хот тохижилт, бүтээн байгуулалтын ажлуудыг стандартын дагуу чанартай гүйцэтгүүлэх зорилгоор Нийслэлийн 9 дүүрэг, Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг болон харьяа газруудад 42 төрлийн нийт 9843 ширхэг хотын стандартын арга

		<p>зүйн баримт бичгийг хүлээлгэн өгч стандартын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.</p>
4	<p>Орчны аюулгүй байдлын мэдээлэл, бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, хяналт тавих, бодит мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтан, олон нийтэд ил тод, нээлттэй хүргэх;</p>	<p>Мэдээллийн сангийн хөгжүүлэлт, Мэдээллийн сангийн боловсруулалт, баяжилт шинэчлэлт, Сэдэвчилсэн зураг бэлтгэх гэсэн 3 үндсэн чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - “Орчны аюулгүй байдлын мэдээллийн систем байгуулах” техникийн төсөл, эдийн засгийн үндэслэл боловсруулсан. - Орчны аюулгүй байдлын мэдээллийн сангийн Барилга байгууламжийн дэд мэдээллийн санд иргэд, аж ахуйн нэгжийн бөглөж байгаа ашиглалтад оруулах барилга байгууламжийн бүртгэлийн мэдээллийг холбож өгснөөр тус мэдээллийг газарзүйн мэдээллийн QGIS программд харах боломжтой болгон Qt designer программыг ашиглан feature attribute-ийг 5 төрлөөр үүсгэж, Орчны аюулгүй байдлын мэдээллийн сангийн барилга байгууламжийн дэд санд харагдах харагдалтыг сайжруулав. - Иргэдийн амьдрах орчны аюулгүй байдал, стандарт, нормын зөрчилтэй холбоотойгоор “Сууц өмчлөгчдийн холбоодод түвшин тогтоох үзлэг шалгалт зохион байгуулах” ажлын хэсгийн судалгаанд зориулан гар утасны болон вэб аппликейшнийг хотын стандартын 7 баримт бичгийн 56 шалгах асуулттайгаар үүсгэв. - Нийслэлийн эрүүл, аюулгүй байдлын индекс тооцох аргачлалыг судлан, тус индексийг тооцоход шаардагдах 7 бүлэг, 29 шалгуур үзүүлэлтийн өгөгдөл, мэдээллийн жагсаалтыг гаргав. - Нийслэлийн нутаг дэвсгэрт Улс, нийслэл, дүүргийн төсөв, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2020-2021 онд дамжин хийгдэх, 2021, 2021-2022 онд хийгдэх тохижилт, бүтээн байгуулалтын ажлын мэдээллээр мэдээллийн санг баяжуулав. - Олон жил ашиглаагүй орхисон ухсан нүхтэй, хог хаягдалтай 10 байршил, нийтийн эзэмшлийн зам талбайг хашаалсан 19 байршил, барилга угсралтын ажил зогссон сургууль, цэцэрлэгийн 23 байршил, яаралтай тусламж, онцгой, цагдаагийн байгууллагын үйлчилгээ үзүүлэхэд саад учруулж буй орц, гарц хаасан хашаа объектын 82 байршил, нийт 134 байршлын судалгааг хийж, мэдээллийн санг баяжуулан, сэдэвчилсэн зураг бэлтгэв.
	<p>Хүрсэн үр дүн: Орчны аюулгүй байдлын мэдээллийн санг үүсгэж шаардлагатай мэдээлээр баяжилт тогтмол хийгдснээр удирдлагыг бодито мэдээллээр хангаж байна.</p>	
5	<p>Хотын стандарт, техник зохицуулалтын баримт бичгийн</p>	<p>Хотын стандартын баримт бичиг боловсруулах, орчны аюулгүй байдлын судалгаа явуулах, эрсдэл зөрчлийг бууруулах, нийслэлийн хэмжээнд шинээр барьж байгуулсан барилга байгууламж, их засварын ажлыг ашиглалтад оруулах ажлыг нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу хэвийн</p>


	<p>тогтолцоог бий болгох;</p>	<p>гүйцэтгэж цаг үеийн ажлын талаар Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд 4 удаа танилцуулж нийт 22 бүлгийн 97 төрлийн хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгийг боловсруулан Нийслэлийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллав. Мөн хотын стандартын баримт бичгийн тогтолцоог бий болгох ажлын хүрээнд Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэгтэй хамтран ажилласны үр дүнд “Хотын стандарт”-ын талаар эрх зүйн үндэс суурийг бий болгож 2022 оны эхнээс мөрдүүлэх бэлтгэл хангуулан ажиллав. Мөн “Хотын стандарт удирдамж арга зүйн баримт бичгийн тогтолцоо, холбогдох журам”-ын төслийг боловсруулан 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр НЗДТГ-т хүргүүлсэн. “Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль” 2022 оноос хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан 2022 оны нэгдүгээр улиралд тус дүрэм, журмыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулахаар төлөвлөсөн.</p>
	<p>Хүрсэн үр дүн: Хотын стандарт, техник зохицуулалтын баримт бичгийн тогтолцоог бий болгох эрх зүйн үндэс тавигдсан.</p>	
<p>6</p>	<p>Холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах, уялдуулах;</p>	<p>Холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах, уялдуулах чиг үүргийн хүрээнд дараах ажлуудыг хамтран хэрэгжүүлэн хяналт тавьж ажиллав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн Засаг Даргын А/177 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Хот байгуулалт хөгжлийн газруудтай чиг үүргийн хүрээнд хамтран ажиллаж орчны аюулгүй байдал алдагдсан нийт орчны аюулгүй байдал алдагдсан 2277 зөрчил байгаагаас, 1320 байршилд зөрчлөө арилгах хугацаатай мэдэгдэх хуудас өгч 1283 зөрчлийг арилгуулсан. <p>Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/690 дугаар захирамжийн дагуу батлагдсан 5 дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн НЗДТГ, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газартай хамтран Нийслэлийн 9 дүүргийн нийт 61 байршилд хийгдэж буй тохижилт, бүтээн байгуулалтын ажлуудад хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж ажиллав. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нийслэлийн 9 дүүргийн 135 байршилд газрын зөрчилтэй холбоотой захирамжийн гүйцэтгэл, үр дүнг газар дээр нь шалган ажиллав. Хяналт шалгалт хийхэд 107 байршлын зөрчлийг арилгаж, газрыг чөлөөлсөн ба 28 байршилд 71 зөрчлийг илрүүлэв. 2. Газрын дарга С.Төмөрдуламаар ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн хуваарийн дагуу нийт 80 байршилд барилга байгууламжийн ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавин ажиллав. Үүнд: 19 сургууль, 14 цэцэрлэг, 3 бага сургууль цэцэрлэгийн цогцолбор, 2 сургуулийн барилга худалдаж авах, 3 цэцэрлэгийн барилга худалдаж авах, олон нийтийн зориулалттай баригдаж буй 39 барилга байгууламжийн нийт 80 ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавин ажиллав.

		<p>3. НМХГ-ын Дэд дарга Б.Батшагайгаар ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн нийт 23 байршилд ажлын явц, гүйцэтгэлд хяналт шалгалт явуулж ажиллав.</p> <p>4. Газрын Орлогч дарга О.Оджаргалаар ахлуулсан дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн төлөвлөгөө, хуваарийн дагуу Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн нийт 15 байршлын ажилд хяналт тавьж ажиллав. Үүнд: 5 сургууль, 5 цэцэрлэг, 3 эрүүл мэндийн байгууллага, 2 их засвар шинэчлэл, тоног төхөөрөмжийн ажил дээр тус тус хяналт тавьж ажиллав.</p> <p>Тус ажлын хэсгийн ажлын тайланг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан.</p>
	<p>Хүрсэн үр дүн: Байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах, уялдуулах чиг үүргийн хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж орчны аюулгүй байдлыг хангуулах, эрсдэлийг бууруулах талаар дээрх арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж нийслэлийн удирдлагаас өгсөн цаг үеийн үүрэг даалгаврыг бүрэн хангалттай биелүүлэн ажилласан.</p>	
7	<p>Хотын стандарт, техник зохицуулалтын баримт бичгийн санг бүрдүүлэх, хөтлөх, баяжуулах, түгээх;</p>	<p>Байгууллагын дотоод мэдээллийн сангийн загварыг гаргаж, html кодыг боловсруулан хотын стандартын арга зүйн баримт бичгийн сангийн мэдээллийг тогтмол баяжуулан ажиллав.</p> <p>2021 оны байдлаар НЗД-ын захирамжаар батлагдсан 22 бүлгийн 97 хотын стандарт арга зүйн баримт бичгийн цахим архивыг бүрдүүлж, баримт бичгийн санг үүсгэсэн.</p>
	<p>Хүрсэн үр дүн: Хотын стандарт, удирдамж арга зүйн баримт бичгийг бүртгэх дугаарлах, нэр өгөх бүлэглэл, ангиллын шаардлагыг боловсруулж цаашид хотын стандартын санг бүрдүүлэн, хөтлөх сонирхогч байгууллага, иргэн, аж ахуйн нэгжүүдийг мэдээллээр хангах боломж бүрдэж байна.</p>	
8	<p>Хотын стандартын талаар зөвлөгөөн, сургалт, сурталчилгаа зохион байгуулах</p>	<p>Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Стандарт, норм, дүрмийг мөрдүүлэх арга хэмжээний тухай” А/276 дугаар захирамжийн хүрээнд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, дүүргүүдийн Засаг даргын тамгын газрын албан хаагчдад стандартын удирдамж арга зүйн баримт бичгийн талаар нэгдсэн ойлголт өгөх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Оюунчимэгээр батлуулсан. Батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу Нийслэлийн Сургалт судалгааны төвтэй хамтран 12 удаагийн сургалтыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад цахимаар зохион байгуулан нийт 740 албан хаагчдыг хамруулан ажиллав.</p>
	<p>Хүрсэн үр дүн: Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагууд Чанар, стандартын ерөнхий ойлголт, хотын стандартын талаар мэдлэг ойлголттой болсон.</p>	
9	<p>Барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах.</p>	<p>Нийслэлийн Засас даргын 2020 оны А/1022, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 317, 2021 оны 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/862 дугаар захирамжийн дагуу Барилгын их засвар, шинэчлэлт, тохижилт, барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах тухай 37, гадна цахилгаан хангамжийн 39 нийт 76 хуваарийг боловсруулан батлуулж хуваарийн дагуу комиссын үйл ажиллагааг зохион байгуулан ажиллав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Барилга байгууламжийн 360, - Их засвар, шинэчлэлт, тохижилтын 490 - Гадна цахилгаан хангамж, гэрэлтүүлгийн 751

		<p>- Шугам сүлжээ 78 2021 онд 2022 комисс ажиллуулах тухай хүсэлт ирүүлсэнээс нийт 1679 байршилд барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулан ажиллав.</p>
	<p>Хүрсэн үр дүн:</p>	<p><i>Барилга байгууламжийг ашиглалтад оруулах тухай иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийг e-mongolia цахим системээр хүлээн авч судлах, барилга байгууламжийг мэдээллийг цахим аппликэйшн ашиглаж баяжуулж эхэлсэн нь комиссын үйл ажиллагааг хурдан, шуурхай зохион байгуулах талаар ахиц дэвшил гаргасан. 2021 онд барилга байгууламжийг ашиглалтад оруулах нийт 1032 хүсэлтийг баталгаажуулав.</i></p> <ul style="list-style-type: none"> - Барилга- 288 - Гадна цахилгаан хангамж-510 - Шугам сүлжээ-45 - Их засвар шинэчлэлт, тохижилт-189

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

3.1 Нийслэл хотыг хөгжүүлж иргэдийг эрүүл, аюулгүй амьдралын орчин, чанар, стандартын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангахад Хотын стандарт, хяналтын газрын оролцоо өндөр ач холбогдолтой тул байгууллагын бүхий л үйл ажиллагааг чиглүүлэх алсын харааг нийт хамт олноороо хэлэлцэж дараах байдлаар тодорхойлов.



Нийслэл хотын иргэдийн амьдралын чанарыг сайжруулах хотын стандартын тогтолцоог хөгжүүлнэ.

3.2 Хотын стандарт, хяналтын газрын нийт албан хаагчид байгууллагынхаа алсын харааг бүрэн агуулгаар нь ойлгож, страаеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн төлөө албан тушаалын зорилго, зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөг уялдуулан боловсруулж төрийн албан хаагчийн манлайллыг хэрэгжүүлэн ажиллах эрхэм үүрэгтэй.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛ, ЗАРЧИМ

4.1 Байгууллагын эрхэм зорилго нь:

“Улаанбаатар хотын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх замаар хувь нэмрээ оруулна”

4.2 Байгууллагын үнэт зүйл, үзэл баримтлал

Хотын стандарт, хяналтын газар нь алсын хараандаа хүрэхийн тулд үйл ажиллагаандаа дараах үнэт зүйлсийг төлөвшүүлж бүх хамт олноороо дээдлэн ажиллах болно.

ҮНЭТ ЗҮЙЛ

ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Ёс зүй	Төрийн албаны ёс зүйг дээдлэн сахиж, үнэнч шударга, ил тод байдлыг эрхэмлэн ажиллана.
Манлайлал	Нийслэл хотын хөгжлийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд идэвхи, санаачлага, хүсэл зориг, хөдөлмөр, зүтгэлээр бусдыг үлгэрлэн манлайлна.
Хамт олон	Албан хаагч бүрийг сурч хөгжих нөхцөлийг бүрдүүлж, нийслэл хотынхоо төлөө урам зориг, эрч хүчтэйгээр ажиллах сэтгэл зүйн болон ажлын таатай орчныг бий болгох байгууллагын соёлыг төлөвшүүлнэ. <i>/Дуугарвал дуу нэгтэй, дугтарвал хүч нэгтэй/</i>
Хариуцлага	Хариуцсан ажлынхаа чанар, гүйцэтгэлийг төлөвлөсөн хугацаанд нь, зорилтот түвшинд нь хүргэхийн төлөө оюун ухаан, хүч хөдөлмөрөө дайчлан ажиллана.
Ур чадвар	Орчин үеийн техник, технологи, ололтот туршлагыг эзэмшиж үнэ цэнээ нэмэгдүүлэн төрийн албан хаагч болон хувь хүний хувьд тасралтгүй хөгжинө.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Орчны шинжилгээний зорилго нь байгууллагын үйл ажиллагааны зарчим, хөгжлийн үе шатуудыг төлөвлөх, стратегийн зорилго, зорилт, шийдвэрийг оновчтой тодорхойлохын тулд Нийслэлийн хэмжээнд стандарт хэрэгжүүлж буй өнөөгийн тогтолцоо, түүний үр дүн, мөрдөгдөж буй стандарт, норм, дүрмүүд, төрийн албан хаагчдын ойлголт, хандлага, орчны аюулгүй байдлын нөхцөл байдал, байгууллагын нөөц, боломж, өнөөг хүртэл хэрэгжүүлсэн ажлын үр дүн зэрэг мэдээллийг нэгтгэн судалж дүн шинжилгээ хийх юм.

5.1 Гадаад орчны шинжилгээ:

Гадаад орчны шинжилгээ нь (PESTLE-улс төр, эдийн засаг, нийгэм, технологи, эрх зүй, байгаль орчин) бичил судалгааны үр дүнд тулгуурлаг тодорхойлох юм.

5.1.1 Эдийн засаг

Дэлхий нийтэд Коронавирусын цар тахал дэлгэрсэнтэй холбоотойгоор Монгол улсын эдийн засагт сөрөг нөлөөлөл үзүүлж байна. Дэлхийн банкнаас 5 ба түүнээс дээш тооны ажилтантай хөдөө аж ахуй, уул уурхай, барилга болон бусад салбарыг төлөөлөхүйц 360 компанийг түүвэрлэн цуврал судалгаа хийсэн байна. Судалгаанд оролцсон нийт аж ахуйн нийт эрхлэгчдийн 82 хувь нь 2020 оны 8-р сард бэлэн мөнгөний хомсдолд орсон байсан бол 2021 оны 2-р сарын байдлаар тус үзүүлэлт 99 хувьд хүрсэн байна. Хугацаанд санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөртэй ААН-үүдийн хувь хэмжээ 27 хувиас 76 хувьд хүрч өссөн байна. Эдийн засгийн энэхүү өөрчлөлт нь санхүүгийн хямралд орсон аж ахуй нэгж байгууллагуудад стандартыг дагаж мөрдүүлэх хэвшүүлэх үйл ажиллагаанд томоохон хүндрэл учруулж байгаа юм.

Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол батлагдсан. Улсын төсөвт хэмнэлт үүсгэж төсвийн тандалт хийсэн нь 2020, 2021 онуудад тус газар үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүндрэл бэрхшээл үүсгэсэн байна.

Үйл ажиллагааны үндсэн чиглэлд зааснаар:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.5-д “Хотын стандартын норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх”

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 5.3.1-д: “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад болон олон улсын чанарын менежментийн тогтолцоо, стандартыг нэвтрүүлэх” зэрэг зорилт, арга хэмжээнд шаардагдах төсөв, зардлыг төлөвлөгөөгүй байгаа нь цаашид үндсэн үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэхэд хүндрэл, эрсдэл үүсгэх юм. Эдийн засгийн хүндрэлээс үүдэлтэй төсвийн хүрэлцээгүй байдал нь 2022 онд тус байгууллагаас олон улсын стандартыг судалж, нутагшуулах ажилд сөргөөр нөлөөлөх эрдсэлтэй байна.

Коронавирусын цар тахлын нөлөөгөөр хүмүүсийн дунд хөл хорио тогтоож, хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан төрийн болон хувийн хэвшлийн үйл ажиллагаа доголдож, эдийн засгийн хүндрэл учирч иргэд, аж аухйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаа явуулах суурь чадамжийг багасгаж байгаа нь тус газрын үндсэн чиг үүрэг болох иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, Хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн мөрдүүлэх, хяналт тавих чиг үүргээ гүйцэтгэхэд саад учруулж байна.

5.1.2 Нийгэм соёл

Тус газар нь 2019 онд үүсгэн байгуулагдаж, дэлхийн жишигт нийцүүлэн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл байдлыг хангуулах нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж, хот төлөвлөлт хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх хотын стандартын удирдамж арга зүйн 22 бүлгийн 97 баримт бичгийг боловсруулан иргэд аж ахуй нэгж байгууллагуудад сурталчилан дагаж мөрдүүлэн ажиллаж байна.

Улаанбаатар хотод 2020 оны байдлаар 1539810 хүн буюу монгол улсын хүн амын талаас дээш хувь нь нийслэл хотод оршин сууж байна. Хүн амын дунд хотжих хөдөлгөөн ихэсч буйтай холбогдуулан иргэдийн Хотын стандартын талаарх мэдлэг ойлголтыг нэн тэргүүн нэмэгдүүлэх шаардлагатай байна. Иймд тус газраас Улаанбаатар хотын оршин суугчийн гарын авлага UCS0107:2020, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага UCS0201B:2020 -ыг боловсруулсан.

Тус газар нь Нийслэлийн соёл урлагийн газартай хамтран “Хотын соёл” аяныг зохион байгуулж байна. Тус аяны хүрээнд байгууллагууд соёлыг төлөвшүүлэх, иргэдэд

үзүүлж буй төрийн үйлчилгээний соёлыг дээшлүүлэх талаар тодорхой үр дүн бүхий олон талт ажлуудыг шинээр санаачлан хэрэгжүүлж, түүнийгээ олон нийтэд сурталчлан, Улаанбаатар хотын оршин суугчдад соёлтой иргэн байхыг таниулан ажиллаж байна. Тухайлбал МУИС, ШУТИС, АШУҮИС, ХААИС-уудад шинээр элсэн орсон 15000 гаруй оюутан залууст зориулсан хотын стандарт, хотын иргэний эрх үүргийг таниулах сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттай зохион байгуулж байна.

Мөн Монгол улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 106.4 мянган хүн байгаагаас нийслэл хотод 36.7 мянга буюу 34.5 хувь нь амьдарч байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчныг сайжруулах, дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, тэдгээрийг чөлөөтэй ашиглах, нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах хэрэгцээ, шаардлага үүсээд байна.

Иймд тус газраас хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, нийгмийн бүхий л харилцаанд бүрэн дүүрэн оролцох, ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, тэдэнд ээлтэй нийгмийн дэд бүтцийн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэд бүтцийн хүртээмжийг дээшлүүлэх арга зүйн удирдамж
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэд бүтцийн техникийн зураг төсөл удирддамж арга зүйн баримт бичгүүдийг тус тус боловсруулан дагаж мөрдүүлж байна. Тус газраас хороо, өрхийн эмнэлгийн цогцолбор барилгуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлын судалгааг нийт 161 хороонд хийснээс 90 хороо буюу 62% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу замтай боловч түүнээс шаардлага хангаж байгаа нь 48 хороо буюу нийт судалгаа ирүүлсэн хорооны 30% нь хороо, өрхийн эмнэлгийн цогцолбор барилга хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байна гэсэн судалгааны дүн гарсан. Хороо, өрхийн эмнэлгийн цогцолбор барилга нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлын судалгааны дүнд 113 хорооны налуу стандартын шаардлага хангахгүй, сайжруулах шаардлагатай байна.

5.1.3 Хууль эрх зүйн хүрээнд:

Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй бадлыг хангах, хотын стандарт, норм дүрмийг боловсруулах, мөрдүүлэх, хяналт тавих, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн хүрээнд Монгол улсыг хөгжүүлэх урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигт Нийслэл хотыг “Хууль, эрх зүйн тогтвортой орчинтой, хотын дүрэм стандартыг хангуулсан хот болж хөгжинө” гэж заасан. Энэ зорилтын хүрээнд 9.4.2 *Хотын нэгдсэн стандартыг боловсруулж мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх тогтолцоог бий болгох*” гэж тусгагдсан байна.

“Алсын хараа-2050” бодлогын баримт бичигт тусгагдсанаас өөрөөр 2021 оныг хүртэл хотын стандартыг дагаж мөрдүүлэх хууль тогтоомж батлагдаагүй байсан бол Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиудын 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх шинэчилсэн найруулгад дараах байдлаар Хотын стандартыг дагаж мөрдүүлэхээр дараах байдлаар тусгаж өгсөн нь хууль эрх зүйн хүрээнд Нийслэл хотод стандартыг дагаж мөрдүүлэх эрх зүйн суурь чадамж үүсээд байна. Үүнд:

Газрын үйл ажиллагааны эрх зүйн орчин

Хууль	Зүйл, заалт
Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль:	Нийслэлийн чиг үүрэг: 24.1.15.хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалт;
Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх 21.1.3 нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэх талаар хуульд нийцүүлэн дүрэм, журам, стандарт заавар батлах Нийслэл хотын оршин суугч дараах үүрэгтэй: 32.2.3 нийслэл хотын дүрэм, стандартыг дагаж мөрдөх
Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хууль	10¹ дүгээр зүйл. Хотын стандарт. 10 ¹ .1. Хотын удирдлагаас иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах чиг үүргийнхээ хүрээнд стандарт батлан хэрэгжүүлж болно. 10 ¹ .2. Хотын стандарт нь үндэсний стандарт, техникийн зохицуулалтын үзүүлэлт, шаардлагад нийцсэн байна.

Дээрх хууль тогтоомжийн дагуу хотын стандартын эрх зүйн үндэс суурь бүрэлдэн тогтсон байна.

“Хотын стандарт” гэх ойлголтыг хуулинд тодорхойлсон боловч түүнийг хэрхэн санаачлах, боловсруулах, батлуулах, мөрдүүлэх үйл явцыг нарийвчлан зохицуулах шаардлага зүй ёсоор тулгарна.

Одоогийн байдлаар:

- Монгол Улсын хэмжээнд нийт 7008 үндэсний стандарт, 422 барилгын норм дүрэм дагаж мөрдөгдөж байна.
- Эрх зүйн баримт бичгүүд:
- Үндэсний чанарын хөтөлбөр /ЗГ 2016 оны 344 -р тогтоол/
- Монгол улсын стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль
- Барилгын тухай хууль
- Барилгын норматив баримт бичгийн тогтолцоо - БНБД 0-01-99
- Барилгын норм ба дүрэм -442 дагаж мөрдөгдөж байна.

Байгаль орчин:

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/995 дугаар захирамжийн дагуу тус газраас нийслэлийн хэмжээнд орчны аюулгүй байдал алдагдсан зөрчлийн талаар судалгаа Төвийн шугам сүлжээнд холбогдоогүй худалдаа үйлчилгээний байгууллагуудад нийтийн бие засах газрын стандартад нийцүүлэх, мөрдүүлэх ажлын хүрээнд судалгаа хийсэн. Үүнд "UCS0704B:2020 Бие даасан инженерийн дэд бүтэц, Бохир усны цооног, бие даасан цэвэрлэх байгууламж"-ийн стандартын шаардлага хангаагүй төвийн шугам сүлжээнд холбогдоогүй худалдаа үйлчилгээний байгууллагуудад нийтийн бие засах газраас 3077 зөрчил илэрсэн байна. Нүхэн жорлон ашиглах нь хөрс, агаарын болон ундны усны бохирдол үүсэхэд ихээхэн нөлөөлж байгаа нь байгаль орчинд сөргөөр нөлөөлж байна.

Орчны аюулгүй байдал

Тус байгууллага нь үүсгэн байгуулагдсан үеэс буюу 2019 оноос эхлэн Нийслэлийн хэмжээнд орчны аюултай байдал үүсгэж, иргэдийн амьдрах орчинд эрсдэл учруулж байгаа газруудын судалгааг гаргаж цаашид стандарт шаардлага хангуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, шаардлага хангуулах тал дээр хяналт тавих ажлуудыг зохион байгуулав. Үүнд:

СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛ	ТООН ҮЗҮҮЛЭЛТ	СУДАЛГААНЫ ҮР ДҮН
ЕБС-ийн гадна орчин	256	Улсын өмчийн 147 ерөнхий боловсролын сургууль, хувийн өмчийн 109 ерөнхий боловсролын сургууль нь стандартын баримт бичгийн шалгуур үзүүлэлтийг хэрхэн хангаж буй үзүүлэлтээр судалгааг хийхэд нийт стандартын шаардлага хангаагүй 70 сургууль байна.
Хүүхдийн тоглоомын талбай	976	Нийслэлийн 9 дүүрэгт 976 хүүхдийн тоглоомын талбай байгаагаас стандартын шаардлага хангуулах шаардлагатай нийт 637 хүүхдийн тоглоомын талбай байна.
Барилгын гадна орчны аюулгүй байдал	307	Барилга угсралтын талбайн түр хашааны стандартыг хангуулах шаардлагатай нийт 307 барилга угсралтын түр хашаа, үүнээс мэдэгдэл хүргүүлсэн 260, зөрчил арилгасан 121, арилгах шаардлагатай-186.
Тээврийн хэрэгсэл, явган хүний зорчих хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх байршлууд	93	Иргэдийн амьдрах орчныг сайжруулах зарим арга хэмжээ буюу авто зам, явган хүний замын орц гарц бий болгох, авто машины болон явган хүний хөдөлгөөнд саад учруулж буй хашаа, хайс, объектыг чөлөөлөх шаардлагатай байгаа Нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд нийт 93 байршлаас 2020 онд 11 байршилд газар чөлөөлөлт хийгдэж, одоогоор чөлөөлөх шаардлагатай 82 байршил байна.

Гадна авто зогсоолын стандартын шаардлагад нийцсэн эсэхэд нэгдсэн судалгааг хийх	71	Нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд 2020 оны байдлаар 71 байршилд 1837 тээврийн хэрэгслийн багтаамжтай төлбөртэй зогсоол гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд Нийслэл хотын хэмжээнд шинээр төлөвлөж болох байршлын судалгааг хэрэгжүүлж тодорхойлох, “Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх байгуулахад тавигдах ерөнхий шаардлага”-ыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.
Цэцэрлэгийн гадна орчин	205	Нийслэлийн хэмжээнд 260 цэцэрлэг байгаагаас судалгаанд хамрагдсан 205 цэцэрлэгээс сайжруулах стандарт хангуулах шаардлагатай нийт 139 цэцэрлэг байна.
СӨХ-ийн гадна орчин /орчны тохижилт, ногоон байгууламж, авто зогсоол/	1154	Нийслэлийн 9 дүүргийн 1154 СӨХ судалгааны материал, фото зургийн хамт ирүүлсэн. 9 дүүргээс шаардлага хангаж байгаа нийт 587 СӨХ, сайжруулах шаардлагатай нийт 345 СӨХ, шаардлага хангахгүй нийт 222 СӨХ байна. Судалгаа ирүүлсэн СӨХ-ны 51% нь шаардлага хангаж байгаа бол 49% нь сайжруулах шаардлагатай болон хангалтгүй байна.
Нийтийн тээврийн зогсоолын стандартын хэрэгжилт	931	Нийслэлийн хэмжээнд нийт 931 автобусны буудал байгаагаас стандартын дагуу тохижуулах шаардлагатай нийт 720 автобусны буудал байгаа бөгөөд Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд нийт 10 автобусны буудал тохижуулахаар гэрээ хийгдсэн.
Барилга угсралтын ажил зогссон сургууль, цэцэрлэгийн байршлуудын судалгаа	23	Нийслэлийн хэмжээнд 2020 онд хийгдсэн урьдчилсэн судалгаагаар барилгын ажил дутуу хийгдэн орхигдсон, хамгаалалтын хашаагүй, арматур төмөр зангидан ил задгай орчны аюултай байдал үүсгэсэн Ерөнхий боловсролын сургууль болон хүүхдийн цэцэрлэгийн царцсан барилгын 23 байршил байна.
Орчны бохирдол үүсгэсэн, удаан хугацаанд ухсан нүхтэй, овоолсон шороотой, эвдэрч нурсан хашаатай газрын байршлууд	43	Орчны бохирдол үүсгэн удаан хугацаанд ухсан нүх, овоолсон шороо, эвдэрч нурсан хашаатай 43 байршил болон Нийслэлийн нутаг дэвсгэрт газар эзэмших гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлээгүй, гэрээнд заасан зориулалтын дагуу газраа 2 жил дараалан ашиглаагүй 32

<p>Нийтийн эзэмшлийн талбайгаар тохижуулах боломжтой байршлын судалгаа</p>	<p>32</p>	<p>байршлын судалгааг гаргаж нийт 75 байршилд улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан 37 байршилд газрын тухай хуулийн 40.1 дэхь заалтын дагуу нийтийн эзэмшилд авч тохижуулах саналыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас боловсруулж байна.</p>
--	-----------	---

Дүн шинжилгээгээр нийт 7329 зөрчил илэрсэн нь Нийслэл хотод стандартын шаардлага хангахгүй иргэдийн амьдрах орчинд эрсдэл учруулж буйг харуулж байна.

Технологи:

Дэлхийн ихэнх улс шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан мэдлэгийн эдийн засаг, дэвшилтэт болон өндөр технологийг хөгжүүлэх, хөрөнгө, нөөцийг төвлөрүүлэх замаар хөгжлийн бодлогоо тодорхойлж, эдийн засгийн төрөлжилтийг бий болгох, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд анхаарал хандуулж байна. Нийслэл хотын хэмжээнд нийтийн үйлчилгээ, ундны усны хангамж, нийтийн тээвэр, боловсрол, эрүүл мэндийн хүртээмж, хог хаягдлын менежмент, цагдаагийн хэсэг зэрэг төрөөс үзүүлж буй нийтийн үйлчилгээ, нийтийн эзэмшлийн бүс, үерт өртөх магадлал бүхий аюултай бүс, гудамжны гэрэлтүүлэг, гэмт хэрэг гарах магадлал өндөртэй цэгүүдийг харуулсан орчны аюулгүй байдлын системийг ашиглаж байна. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын засаглалыг сайжруулах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад үзүүлэх төрийн үйлчилгээний шат дарааллыг багасгах, үйлчилгээг цахимжуулах, нийслэлийн харьяа газруудын үйл ажиллагаандаа ашиглаж буй мэдээллийн системийг дахин төлөвлөх, орчин үеийн ухаалаг нэгдсэн системд шилжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын “Нэг тархи нэгдсэн систем” төслийг боловсруулан, 2021-2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Ингэснээр технологийн дэвшлийг ашиглан иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд илүү таатай орчин бүрдээд байна.

Улс төр

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал нь нийслэл хотын нийт иргэдийн төлөөлөл болон сонгогдсон 45 төлөөлөгчтэй. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь Монгол ардын нам-34, Ардчилсан нам-8, Хөдөлмөрийн Үндэсний нам -3 тус тус бүрдэх бөгөөд дээрх улс төрийн намууд нь Улаанбаатар хотод стандартын хэрэгжилтийг сайжруулах, хотын стандартыг боловсруулан мөрдүүлэх талаар нэгдмэл байр суурьтай байна.

НИТХ-аас стандарт, нормын хэрэгжилттэй холбоотой дараах шийдвэр, үйл ажиллагааг 2021-2022 онд хэрэгжүүлж байгаа нь нийслэлийг хөгжүүлэх бодлогын баримт бичигт хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх ажил ахиц дэвшилтэй, амжилттай байхад эерэгээр нөлөөлнө гэж тооцож байна. Үүнд:

- Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2021 оны “Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хэрэглэгчийн эрхийг хамгаалж хүртээмжийг сайжруулах тухай” А/13 дугаар захирамж
- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2021 оны 09 дүгээр сарын 30-ны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/130 дугаар захирамжаар “Стандарт, нормын хэрэгжилтийн байдал, хүчин төгөлдөр стандартыг шинэчилж сайжруулах талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгүүд тус тус байгуулагдан ажиллаж байна.

5.2 Дотоод орчин:

5.2.1 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж:

Нийслэл Улаанбаатар хот нь засаг захиргааны нэгжийн хувьд 9 дүүрэг, 173 хороодоос бүрддэг бөгөөд цаашид төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдийн хороодыг хувааж тоог нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байна. Монгол Улсын засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 360 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч 34 агентлагийн бүтцийг шинээр тогтоох үйл явц хэрэгжиж 2022 оны 02 дугаар сараар шинэ бүтэц, зохион байгуулалтын дагуу үйл ажиллагаа жигдэрч байна.

Дээрх нутгийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалт нь тус газрын үйл ажиллагаанд хамаарал бүхий байгууллагуудын чиг үүрэгт хотын стандартын тогтолцоог бүрдүүлэх, түүнд хэрхэн оролцох талаар илүү нарийн, тодорхой тусгажээ. Энэ нь хотын стандартыг санаачлах, боловсруулах, батлуулах гэх мэт тус газрын үндсэн чиг үүрэгт бусад байгуулалтын зүгээс санал өгөх, хотын стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих гэх мэт чиг үүргийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Хот байгуулалт, хөгжлийн газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба зэрэг байгууллагуудтай тогтмол харилцаж хамтран ажиллах шаардлагатай болно.

5.2.2 Бүтэц, зохион байгуулалт

Хотын стандарт, хяналтын газар нь Нийслэлийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/1059 дүгээр захирамжаар удирдлага /дарга, орлогч дарга/, зохион байгуулалтын 6 нэгж, нийт 60 хүртэлх албан хаагчтай байхаар бүтэц, орон тоог шинэчлэн батлагдсан. Бүтцийн нэгжид дараах өөрчлөлт орсоноор газрын чиг үүргийг хэрэгжүүлэхэд илүү оновчтой зохион байгуулалт бий болсон.


Шинэчилсэн бүтцийн харьцуулалт

Өмнөх бүтэц /НЗД-ын 2020 оны А/1011 дүгээр захирамж/	Шинэчилсэн бүтэц /НЗД-ын 2021 оны А/1059 дүгээр захирамж/
<ul style="list-style-type: none"> - Удирдлага /дарга, орлогч дарга/ - Захиргааны хэлтэс - Бодлого төлөвлөлтийн хэлтэс - Стандарт хэрэгжүүлэлтийн хэлтэс - Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтэс - Барилга байгууламжийн хяналтын хэлтэс - Мэдээлэл технологийн хэлтэс 	<ul style="list-style-type: none"> - Удирдлага /дарга, орлогч дарга/ - Захиргаа, санхүүгийн хэлтэс - Хотын хөгжлийн стандартын хэлтэс - Хот нийтийн аж ахуйн стандартын хэлтэс - Худалдаа, үйлчилгээний стандартын хэлтэс - Байгаль орчны стандартын хэлтэс - Стандартын хэрэгжилт, хяналтын хэлтэс

Дээрх бүтцийн дагуу газрын чиг үүргийг нэгж хооронд дараах байдлаар хуваарилсан.

1. Захиргаа, санхүүгийн хэлтсийн төсөв, санхүүгийн чиг үүргийг илүү нарийвчлан тодорхойлсон.
2. Хотын стандартыг боловсруулах, суурь судалгаа, хийх батлуулах чиг үүргийг Бодлого төлөвлөлтийн хэлтэс нь дангаар хэрэгжүүлдэг байсныг ХХСХ, ХНААСХ, ХҮСХ, БОСХ-үүд салбар чиглэл бүрээр нь төрөлжүүлэн задалж хариуцуулав.
3. Нийслэл хотод стандарт мөрдүүлэх талаар зөвлөн туслах, арга зүйгээр хангах, хяналт тавих чиг үүргийг Стандарт хэрэгжүүлэлтийн хэлтэс, Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтсүүд хариуцдаг байсныг шинээр зохион байгуулсан Стандартын хэрэгжилт, хяналтын хэлтэст хариуцуулсан.
4. Байгаль орчны стандартын хэрэгжилтэд хяналт тавьж зөрчлийг арилгах чиг үүргийг Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтэс хариуцдаг байсныг Байгаль орчны стандартын хэлтэс болгон шинэчлэн зохион байгуулсан.
5. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг Барилга байгууламжийн хяналтын хэлтэс хариуцан зохион байгуулдаг байсныг Стандартын хэрэгжилт, хяналтын хэлтэс болгон шинээр зохион байгуулав.
6. Хотын стандартын бүртгэл мэдээлэл, орчны аюулгүй байдлын мэдээллийн сан, ашиглалтад орсон барилга, байгууламжийн талаарх мэдээлэл нэгтгэн боловсруулах чиг үүргийг холбогдох хэлтсүүдэд нь мэдээллийн технологи, дотоод сүлжээний асуудлыг Захиргаа, санхүүгийн хэлтсүүдэд тус тус хувааж тус хэлтсийг бүтцээс хассан.

Хотын стандарт, хяналтын газрын үндсэн чиг үүргийн дахин хуваарилалт



№	Газрын үндсэн чиг үүрэг	Захиргаа, санхүүгийн хэлтэс	Хотын хөгжлийн стандартын хэлтэс	Худалдаа, үйлчилгээний стандартын хэлтэс	Хот нийтийн аж ахуйн стандартын хэлтэс	Байгаль орчны стандартын хэлтэс	Стандартын хэрэгжилт, хяналтын хэлтэс
1	4.1.1 ... хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх		Нэгдсэн бодлогын хэрэгжилт	Хариуцсан салбарын хүрээнд			
2	4.1.2 ...хотын стандартыг боловсруулах, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих		Хариуцсан салбар, чиглэлээр стандарт боловсруулж батлуулах				Хянах
3	4.1.3 ...удирдамж, арга зүйн тогтолцоог хөгжүүлэх						хэрэгжилтийг хянах, зөвлөн туслах
4	4.1.4 ...лавлагаа, мэдээллийн сан бүрдүүлэх, хөтлөх		Нэгдсэн лавлагаа, мэдээллийн сан бүрдүүлэх	Хариуцсан салбарын хүрээнд			
5	4.1.5 ... мэргэжил, арга зүйн тусалцаа үзүүлэх			Хотын стандартыг хэрхэн батлуулах талаар мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх /бусад байгууллагуудад/			
6	4.1.6 хотын стандартын талаарх сургалт, сурталчилгаа			Хариуцсан салбарын хүрээнд сургалт, сурталчилгаа хийх			
7	4.1.7.. барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комисс						Үндсэн чиг үүрэг

Захиргааны дэмжлэг Үндсэн хариуцах Хамтран ажиллах

5.2.3 Нөөц /хүний нөөц, санхүү, техник, мэдээлэл/

Хүний нөөц: Газрын батлагдсан бүтэц, зохион байгуулалтаар 6 нэгж 60 хүртэлх албан хаагчтай байхаар тогтоосон. 2022 оны 02 дугаар сарын 07 -ны өдрийн байдлаар 40 албан хаагч ажиллаж байна.

Байгууллагын хүний нөөцийн нөхцөл байдлыг авч үзвэл мэргэжлийн чиглэлийн хувьд өргөн салбар чиглэлийг хамарч байгаа ба хот байгуулалт, инженер, чанарын удирдлагын тогтолцооны аудитор мэргэжлээр мэргэжил дээшлүүлсэн байна.

Нийт албан хаагчдын 60% нь албан тушаалдаа жинхлэн томилогдсон, Гадаад хэлний мэдлэг-70%, Мэргэжлийн зэрэг-30%, Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх бэлтгэгдсэн Тэргүүлэх аудитор-9, Дотоод аудитор-19 албан хаагчид байна.

Албан хаагчдын хүйсийн харьцаа адил, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эх, эцэг байхгүй байна.

Хүснэгт 1. Газрын албан хаагчдын боловсрол мэргэжлийн чиглэл

Мэргэжлийн чиглэл	Мэргэшил
<ul style="list-style-type: none"> Хот ба бүс нутаг төлөвлөлт Архитектор Геодезийн инженер Барилгын инженер Цахилгааны инженер Гидрогеологийн инженер Геоэкологи Салбарын инженер Газар зохион байгуулагч Мэдээллийн технологи Төрийн удирдлага 	<ul style="list-style-type: none"> Тэргүүлэх аудитор-10 Дотоод аудитор-19 Мэргэшсэн архитектор-2 Зөвлөх инженер-1 ОУ-ын байгаль орчны манлайлагч-1 Тэргүүлэх архивч-1

<ul style="list-style-type: none">• Эдийн засаг• Эрх зүй• Тэргүүлэх архивч	
--	--

2021 онд газрын үйл ажиллагааг илүү сайжруулах, албан хаагчдын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Чанарын удирдлагын тогтолцоо MNS/ISO 9001:2015 (2016) нэвтрүүлсэн хэдий ч үүсгэн байгуулагдсан цагаас эхлэн өнөөдрийг хүртэл 20 гаруй албан хаагч ажлаас чөлөөлөгдөж, солигдсон нь албан хаагчдын дунд байгууллагын зорилго зорилтыг ойлгуулах нэгдсэн нэг ойлголтыг өгөх, тогтвортой байхад сөрөг нөлөө үзүүлж байна. Иймд шинээр орсон албан хаагчдад байгууллагын соёлыг таниулах, ёс зүй хариуцлагаг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Газрын бүтцээр батлагдсан орон тоог нэн тэргүүн бүрдүүлж ажиллах хэрэгцээ үүсээд байна.

Коронавирусын цар тахлаас үүдэн тус байгууллагын хүний нөөцөд үүссэн асуудлууд:

1. Төрийн албаны зөвлөлийн сонгон шалгаруулалт хийгдэхгүй хойшлогдож байгаа нь ажлын байрны сул орон тоог нөхөн бүрдүүлэхэд учирч буй хамгийн том сөрөг нөлөө үзүүлсэн.

2. Нийслэлийн онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу:

- 2020 онд Шинэ коронавирусын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч иргэдэд зөвлөмж мэдээлэл өгч эргүүлээр ажиллах
- 2021 онд Коронавирусын халдварын үеийн тусламж үйлчилгээнд дэмжлэг үзүүлж Хан-Уул дүүрэгт ажиллах
- Коронавирусын халдвар хамгааллын дэглэмийг аж ахуйн нэгж байгууллагуудад сахиулж QR код шалгах
- “Нэг хаалга-нэг шинжилгээ” зэрэг үйл ажиллагаанд тус байгууллагаас нийт албан хаагчдын тэн хагас нь хамрагдаж ажлын байранд ажиллах нөхцөл үүсэхгүй байгаа нь үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж, албан хаагчдад ноогдох ажлын ачааллыг ихэсгэж байна.

Тус газар нь 2019 онд анх үүсгэн байгуулагдахдаа 20 албан хаагчтайгаар үйл ажилагааг эхлүүлсэн. 2021 онд 40 албан хаагч ажиллаж байгаа хэдий ч 1 албан хаагчид ноогдох ажлын байрны хэмжээ стандартын шаардлага хангахгүй байна. Үүнээс үүдэн албан хаагчдын ажлын бүтээмж буурах, ажиллах боломж хомс байна.

Гадна орчны шинжилгээнд дурдсаны дагуу цар тахлаас үүдсэн тасвийн таналтаас үүдэн албан хэрэгцээнд шаардлагатай бараа бүтэгдэхүүн худалдаж авах, албан хаагчдаас санаачилсан шинэ санал санаачлагыг дэмжих, шинээр ажил зохион байгуулах зэрэг боломж үүсэхгүй байна.

Санхүү:

Улсын эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж байгууллагын урсгал төсөвт үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардал төдийлөн хангалттай тусгагдаагүй, зөвхөн үндсэн цалин, урамшуулалт нь тус газрын нийт төсвийн 70-80%-ийг бүрдүүлж байна.

Хотын стандарт нь бүтээн байгуулалт, ажил үйлчилгээнд нарийн хэм хэмжээ, шаардлага хангуулах чухал баримт бичиг учраас нарийн мэргэшсэн, зөвлөх инженер, техникийн ажилтнууд, эрдэмтдийн зөвлөмж, зөвлөгөө зайлшгүй шаардлагатай ажил байдаг. Тэдгээр өндөр мэргэжлийн зөвлөхүүдтэй хамтран ажиллахад зарцуулах хөрөнгийн эх үүсвэр төдийлөн хангалттай биш байна.

Төсвийн хэмнэлттэй холбойтой МУЗГ-ын 2021 оны 43, 380 дугаар тогтоолын улмаас байгууллагын бичиг хэргийн зардал, шатахууны зардалд хязгаарлалт тогтоосон нь өдөр тутмын үйл ажиллагаанд бага зэргийн хүндрэл, удаашралтай нөхцөл байдлыг бий болгож байна.

Машин, тоног төхөөрөмж

Тус газар нь 2019 онд байгуулагдах үед худалдан авсан тоног төхөөрөмжүүд харьцангуй насжилт бага, үзүүлэлт сайн учраас энэ чиглэлд тохиолдох хүндэлтэй асуудал бага байна. Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах, судалгааны ажил гүйцэтгэх зэрэгт хэрэглэгдэх автомашин нь харьцангуй шинэ, багтаамж сайтай учир унаа, тээвэртэй холбоотой бэрхшээл тохиолдох магадлал бага гэж үзэж байна.

5.3 Орчны шинжилгээний нэгтгэсэн үр дүн /СВОТ шинжилгээ/

Хүчин зүйлс	Гадаад орчин	
	Боломж	Эрсдэл
Улс төр	Хотын стандартыг батлах НИТХ-ыг бүрдүүлэгч улс төрийн нам, төлөөлөгчид хотын стандартын талаар нэгдмэл байр, суурьтай, бүрэн ойлголттой байгаа нь хотын стандартын тогтолцоог хөгжүүлэхэд эерэг үр нөлөөтэй.	Улс төрийн сонгуулийн үр дүнд нийслэлийн удирдлагууд өөрчлөгдөх магадлалтай бөгөөд шинээр томилогдсон удирдлагыг бодит мэдээллээр хангах, ойлголт өгөхөд хүндрэл үүсэх, цаг хугацаа алдах эрсдэлтэй.
Эдийн засаг, санхүү	Цар тахлын дараах эдийн засгийг сэргээх “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг МУЗГ-аас хэрэгжүүлж байгаа нь хотын стандартыг тухайн бодлоготой уялдуулан хөгжүүлэх эерэг үр нөлөөтэй байх боломжтой	Төсвийн хэмнэлтийн горимд ажиллаж байгаа нь газрын дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд мэргэжлийн зөвлөхүүдтэй хамтран ажиллахад бэрхшээл учруулах эрсдэлтэй.
Нийгэм соёл	Улаанбаатар хотод стандартын хэрэгжилтийг сайжруулах талаар иргэдийн оролцоо хийх хүсэл, сонирхол их байгаа нь хотын стандартын тогтолцоог бүрдүүлэхэд чухал түлхэц болно	Стандарт, норм дүрмийн талаар ААНБ, төрийн албан хаагчид, иргэд, олон нийтийн мэдлэг, ойлголт муу байгаа нь стандартын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх магадлалтай.
Байгаль орчин	Агаарын бохирдлыг бууруулах талаар төр, засгаас өндөр ач холбогдол өгч ажиллаж байгаа нь байгаль орчны чиглэлээр, тэр тусмаа агаарын бохирдлыг бууруулах чиглэлд стандарт хэрэгжүүлэхэд тус болно.	Улаанбаатар хотын орчны бохирдлын түвшин өндөр, ундны усны хамгаалалтын зурвасын ашиглалт, хамгаалалт сул байна. Мөн түүнчлэн хууль, эрх зүйн орчныг сайжруулах шаардлага тулгамдаж байна.
Дотоод орчин		
	Давуу тал	Сул тал
Засаг захиргаа,	Нийслэлийн хороодыг хүн ам, төрийн үйлчилгээний ачааллыг	Дүүргүүдийн ЗДТГ болон хороодод иргэдийн амьдрах орчны хяналт,

нутаг дэвсгэрийн нэгж	тэнцвэржүүлэн шинээр хуваан зохион байгуулсан нь хотын стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтийг үнэлэхэд эерэг нөлөөтэй юм.	мониторингийг тогтмол хийж байдаг хороодын хэсгийн ахлагч, төрийн албан хаагчид нь стандарт, нормын талаар мэдлэг ойлголт сайнгүй байгаа тул сургалт, арга зүйгээр хангах ажлыг далайцтай хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.
Бүтэц, зохион байгуулалт	Шинэчлэн батлагдсан дүрэм, чиг үүрэгт нийцүүлэн хотын хөгжлийн бодлого, хот нийтийн аж ахуй, худалдаа, үйлчилгээ, байгаль орчин гэх зэрэг үндсэн салбар, чиглэлээр нь хотын стандартыг боловсруулах, батлуулах үйл ажиллагааг нэгж хооронд тэнцвэртэйгээр хуваарилж шинэчилсэн бүтэц бий болгосон нь ажлын үр дүнг сайжруулах нөхцөл бүрдсэн гэж үзэж байна.	Хотын стандартыг салбар чиглэл бүрээр зохион байгуулахад дан ганц өөрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын хүрээнд ажиллаж үр дүнд хүрэх боломжгүй бөгөөд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай. Өөрөө хэлбэл: Хотын стандартыг амжилттай хэрэгжүүлэхэд
Нөөц	Байгууллага өөрийн чиг үүргээ хэвийн гүйцэтгэхэд шаардлагатай машин тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэлд бүрэн хангагдсан. Нийт орон тоонд шаардлагатай тавилга, компьютер,	Хотын стандартыг боловсруулах, суурь судалгаа хийх зэрэг ажлуудад зарцуулах төсөвлөсөн хөрөнгө дутмаг, түүний зэрэгцээ хотын бүтээн байгуулалт, хөгжлийн асуудлаар нарийн мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэхэд хүндрэлтэй бөгөөд тэдгээрт олгох хүрэлцээтэй цалин, хөлс хязгаарлагдмал байна.

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

6.1 Газрын стратегийн зорилт

Байгууллагын алсан хараа, эрхэм зорилгодоо хүрэхийн тулд 2022-2025 оны хугацаанд дараах стратеги зорилтыг дэвшүүлэн, жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө зохих арга хэмжээг үе шаттайгаар тусган хэрэгжүүлнэ.

- Стратегийн зорилт -1** Хотын стандартыг бий болгож, нийслэлд мөрдүүлэх стандартчиллын баримт бичгийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн сайжруулах
- Стратегийн зорилт-2** Хотын стандартын тогтолцооны эрх зүйн орчныг бүрдүүлэх
- Стратегийн зорилт-3** Стандартын талаарх бүх нийтийн мэдлэг, ойлголтыг төлөвшүүлэх
- Стратегийн зорилт-4** Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангуулж Чанарын удирдлагын тогтолцооны стандартыг нэвтрүүлэх
- Стратегийн зорилт-5** Стандарт, нормын хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулна.